

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2023 оны \_\_\_ сар \_\_\_ өдөр

Дугаар \_\_\_

Улаанбаатар хот

Даатгалын багц дүрэмд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн арваннэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-т дор дурдсан хавсралт, маягтыг нэмсүгэй.

1/45 дугаар хавсралтаар “СЗХ04172А. Даатгалын компанийн цахим даатгалын үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлан”, “СЗХ04172Б. Даатгалын зуучлагч компанийн цахим үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлан; “СЗХ04172В. Даатгалын хохирол үнэлэгч компанийн цахим үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлан”;

2/46 дугаар хавсралтаар “СЗХ04173. Жендерийн талаар дэлгэрэнгүй тайлан”.

2. Мөн зааврын 2.6, 2.7, 2.8 болон 2.9 дэх заалтуудад дор дурдсан агуулга бүхий хэсэг нэмсүгэй.

1/2.6.17, 2.7.18 болон 2.8.10-т “Цахим үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 45 дугаар хавсралтын “А” маягтаар.” гэж;

2/2.9.5-д “Цахим үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 45 дугаар хавсралтын “Б” маягтаар.” гэж;

3/2.10.5-д “Цахим даатгалын үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 45 дугаар хавсралтын “В” маягтаар.” гэж;

4/ 2.6.18, 2.7.19, 2.8.10, 2.9.6 болон 2.10.6-д “Жендерийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ зааврын 46 дугаар хавсралт маягтаар” гэж тус тус нэмсүгэй.

3. Мөн зааврын 2.5 дахь заалтын “хадгаламжийн” гэсний дараа “хуулга болон компанийн хувьцаа, бонд, банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулсан хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулах холбогдох баримт бичгийг” гэж нэмсүгэй.

4. Мөн зааврын 12 дугаар хавсралт “Даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газрын ерөнхий мэдээллийн тайлан” маягтын “Ажиллагчдын тоо/тоогоор/” гэх баганын ард,

“Даатгалын гэрээний тоо /тоогоор/: хувь хүн” гэх баганын ард, “Нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо /тоогоор/: хувь хүн” гэх баганын ард, 33 дугаар хавсралт “Даатгалын зуучлагч компанийн салбар, төлөөлөгчийн газрын дэлгэрэнгүй тайлан” маягтын “Зуучилсан даатгалын гэрээний тоо:хувь хүн” гэх баганын ард, “Нийт ажиллагчдын тоо” гэх баганын ард, 36 дугаар хавсралт “Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар, төлөөлөгчийн газрын дэлгэрэнгүй тайлан” маягтын “Нийт ажиллагчдын тоо” гэх баганын ард тус тус “Үүнээс эмэгтэй” гэх багана нэмсүгэй.

5. Мөн зааврын 2.14 дэх заалтын “2.13-т” гэснийг “2.11-т” гэж, 13 дугаар болон 14 дүгээр хавсралт маягтын нэрний “компанийн” гэснийг “байгууллагын” гэж, 20 дугаар хавсралтын маягтын нэрний “МАЯГТ-Д5-В” гэснийг “МАЯГТ СЗХ04124” гэж, 27 дугаар хавсралтын “2.1” гэснийг “2.4” гэж тус тус өөрчилсүгэй.

6.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны ... дугаар сарын  
...-ны өдрийн ... дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн  
оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах  
заавар”-ын 45 дугаар хавсралт

**МАЯГТ СЗХ04172А. ДААТГАЛЫН КОМПАНИЙН ЦАХИМ ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

Даатгагчийн нэр.....

20...оны ... сарын ...-ны өдөр

№	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Мөрийн дугаар	Хэрэгжүүлж буй хэлбэр*	Нийт даатгалын үнэлгээний дүн	Нийт даатгалын хураамжийн дүн	Нийт даатгалын гэрээний тоо	Даатгалын зүйлийн тоо			Нийт даатгалын нөхөн төлбөрийн дүн	Нийт даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	Нийт даатгалын гэрээний зардлын дүн
							Хүний амь нас, эрүүл мэнд	Эд хөрөнгө	Бусад			
А	Б	В	1	2	3	4	5	5	6	8	9	10
1		1										
2		2										
3		3										
4		4										
5	...	5										
Нийт		6										

\* Гар утасны аппликэйшн, чатбокс болон бусад аливаа төрлийн технологи  
тамга тэмдэг

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Гүйцэтгэх захирал

/...../

/...../

Ерөнхий нягтлан бодогч

/...../

/...../

.....

/...../

/...../

**МАЯГТ СЗХ04172Б. ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ КОМПАНИЙН ЦАХИМ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

Даатгалын зуучлагчийн нэр.....

20...оны ... сарын ...-ны өдөр

№	Зуучилсан даатгагчийн нэр	Зуучилсан даатгалын бүтээгдэхүүний нэр	Мөрийн дугаар	Хэрэгжүүлж буй хэлбэр*	Нийт зуучилсан даатгалын үнэлгээний дүн	Нийт зуучилсан даатгалын хураамжийн дүн	Нийт зуучилсан даатгалын гэрээний тоо	Даатгалын зүйлийн тоо			Нийт зуучилсан даатгалын нөхөн төлбөрийн дүн	Нийт зуучилсан даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	Нийт даатгалын шимтгэлийн дүн
								Хүний амьнас, эрүүл мэнд	Эд хөрөнгө	Бусад			
А	Б	В	Г	1	2	3	4	5	6	7	8	9	10
1			1										
2			2										
3			3										
4			4										
5			5										
Нийт			6										

\* Гар утасны аппликэйшн, чатбокс болон бусад аливаа төрлийн технологи

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гүйцэтгэх захирал

/...../

/...../

Ерөнхий нягтлан бодогч

/...../

/...../

.....

/...../

/...../



“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын 46 дугаар хавсралт

**МАЯГТ СЗХ04173. ЖЕНДЕРИЙН ТАЛААР ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

Даатгагчийн нэр.....

20...оны ... сарын ...-ны өдөр

№	Даатгалын хэлбэр	Мөрийн дугаар	Даатгуулагчийн тоо*	Үүнээс эмэгтэй	Нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо**	Үүнээс эмэгтэй
А	Б	В	1	2	3	4
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	1				
1.1	Үүнээс: Ипотекийн даатгал	2				
2	Хөрөнгийн даатгал	3				
2.1	Үүнээс: Ипотекийн даатгал	4				
3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	5				
4	Ачааны даатгал	6				
5	Барилга угсралтын даатгал	7				
6	Газар тариалангийн даатгал	8				
7	Мал амьтдын даатгал	9				
8	Агаарын хөлгийн даатгал	10				
9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	11				
10	Хариуцлагын даатгал	12				
11	Санхүүгийн даатгал	13				
12	Зээлийн даатгал	14				
13	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	15				
14	Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	16				
15	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	17				
16	Жолоочийн хариуцлагын даатгал	18				
17	Хугацаат амьдралын даатгал	19				
18	Үүнээс: Ипотекийн даатгал	20				
19	Насан туршийн даатгал	21				
20	Үүнээс: Ипотекийн даатгал	22				

21	Хуримтлалын даатгал	23			
22	Тэтгэврийн даатгал	24			
23	Эрүүл мэндийн даатгал	25			
24	Аннуити даатгал	26			

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гүйцэтгэх захирал /...../ /...../

Ерөнхий нягтлан бодогч /...../ /...../

..... /...../ /...../

Маягт нөхөх заавар:

\*Багана “1”-ийг бөглөхдөө даатгалын зуучлагч компани бол зуучилсан даатгуулагчийн мэдээллийг, даатгалын хохирол үнэлэгч компани бол даатгалын хохирлын үнэлгээ хийсэн үйлчлүүлэгчдийн мэдээллийг тайлагнана.

\*\*Багана “3”-ийг зөвхөн даатгалын компани бөглөнө.